



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2024 оны 02 сарын 06 өдөр

Дугаар 45

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө бүртгэх зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Засгийн газрын 2008 оны "Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 148 дугаар тогтоолын 1.6 дэх заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 4.1.2, 4.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2019-2023 онд Хууль зүй, дотоод хэргийн сайдын багцаас санхүүжүүлэн барьж ашиглалтад оруулсан, нийт 5,064,920,189.00 (таван тэрбум жаран дөрвөн сая есөн зуун хорин мянга нэг зуун наян ес) төгрөгийн үнэ бүхий барилга, байгууламжийг хавсралтад заасны дагуу Ховд аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн үндсэн хөрөнгөд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Л.Нямгэрэл, Ховд аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн дарга С.Хоролсүрэн нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хавсралтад заасан үл хөдлөх хөрөнгийг Улсын комиссын акт, санхүүжилт хийснийг баталгаажуулсан эрх бүхий байгууллагын шийдвэр, тооцоо, гүйцэтгэгчээс захиалагчид хүлээлгэн өгсөн баримт дахь хөрөнгө тус бүрийн задаргаа, зориулалтыг харгалзан, байнгын ашиглалтад хүлээн авч, бүртгэх асуудлыг шийдвэрлүүлэх;

2.2. Хөрөнгийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3. Барилгын доорх 3000 м.кв талбай бүхий газар эзэмших эрхийг Сангийн сайдын 2018 оны 08 дугаар сарын 07-ны өдрийн "Аргачлал батлах тухай" 207 дугаар тушаалаар батлагдсан аргачлалын дагуу үнэлж, хараат бус үнэлгээчнээр нягтлан шалгалт хийлгэж, дүнг санхүүгийн тайланд тусгах;

2.4. Арга хэмжээний биелэлтийг 2024 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.


ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ
132006356
4-r huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2024 оны 02 дугаар сарын 08 ны өдрийн
43 дугаар тогтоолын хавсралт



Ховд аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн өмчид бүртгэх үл хөдлөх хөрөнгийн жагсаалт

Д/д	Хөрөнгийн нэр, байршил	Барилгын хүчин чадал	Гүйцэтгэлээрх дүн /төгрөгөөр/	Улсын комиссын актын дугаар
1	Ховд аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс, архивын тасгийн барилга /Ховд аймаг, Жаргалант сум, 4-р баг/	2 давхар, зоорьтой, нийт 2149.26 м2	5,064,920,189.00	ББКД-84-40/23
	Нийт дүн		5,064,920,189.00 (таван тэрбум жаран дөрвөн сая есөн зуун хорин мянга нэг зуун наян есөн)	